



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
ХАРХОРИН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 02 сарын 07 өдөр

Дугаар 108

Хархорин сум

Үнэлгээний хороо байгуулах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 50 дугаар зүйлийн 50.1.1 дэх заалт, 50.2 дахь хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Засаг даргын Тамгын газарт тээвэр шатахуун нийлүүлэх нийлүүлэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Үнэлгээний хорооны дарга: С.Мөнхсоёл (Бэлчээр, газар тариалангийн асуудал хариуцсан мэргэжилтэн)

Гишүүн:

Ш.Оюумаа (Иргэний төлөөлөл)

Нарийн бичгийн дарга:

Б.Пүрэвсүрэн (Багийн Зохион байгуулагч)

2. Худалдан авах ажиллагааг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу зохион байгуулж, нийлүүлэгчийг сонгон шалгаруулж, дүгнэлт гарган танилцуулахыг үнэлгээний хорооны дарга (С.Мөнхсоёл)-д даалгасугай.

3. Тендер шалгаруулалттай холбоотой баримт бичгээр хууль тогтоомжийн дагуу архивын нэгж бүрдүүлж, Архив, бичиг хэргийн эрхлэгчид хүлээлгэн өгөхийг дагуу үнэлгээний хорооны нарийн бичгийн дарга (Б.Пүрэвсүрэн)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

Г.ОДГЭРЭЛ



401100016